

КoВид-н эсрэг яаралтай авах эдийн засгийн зарим арга хэмжээ

Монгол улс дэлхийн олон орноос урьдчилж эрүүл мэндийн бэлэн байдлыг амжилттай хангасан шигээ, эдийн засгийн эрүүл мэнд, ажлын байрыг хамгаалах цогц бодлого нэн шаардлагатай байна. Вирусын тархалтаас зогссон эдийн засагт 230 мянган ажлын байр эрсдэлд оржээ.

Коронавирус дэлхийг нөмөрч байгаа энэ цаг үед нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн онцгой сорилтын өмнө бид тулж иржээ. Онцгой цаг үе онцгой шийдэл шаардана, учир нь бидний мэдэх эдийн засгийн уналт, сэрэлтийн дүрэм энд ажиллахгүй. Эдийн засаг гэдэг холбоотой хоёр мотор дээр эргэдэг машин гэж ойлгий. Нэг хүний зардал нөгөө хүний орлого болж ирдэг, орлого цаашлаад зарлага болно, зарлага нь орлого болсон эцэс төгсгөлгүй тойрог юм. Зогсохгүй эргэлдэж л байвал эдийн засаг ажиллаж байгаагийн шинж.

Коронавирус дэгдэж хөл хорио тогтосноор, хүмүүс өдөр тутмын зарлагаа зогсооно. Нөгөө талдаа байгууллага, арилжаа эрхлэгчдийн орлого тасарч эхлэнэ гэсэн үг. Орлого зогслоо гээд бизнесүүдийн тогтмол зардал үргэлжилсэн хэвээр: түрээсээ төлөх, тог цахилгааны төлбөрүүд, нийгмийн даатгал, ажилчдын цалин. Орлого тасарсан аж ахуйн нэгж удаан зардлаа төлөөд оршин тогтнож чадахгүй. Үүнээс улбаалж, ажилчдаа цомхотгоно, иргэд орлогогүй болч, эдийн засаг зогсоно.

2020 оны 1 дүгээр сарын сүүлээс бүтэн болон хэсэгчилсэн хөл хорио тависнаас хойш, Монголын бизнесүүдийн орлого огцом буурч эхэлж байна. Энэ хугацаанд аж үйлдвэрлэл, уул уурхай, агаарын тээвэр, НӨАТ орлого бүгд 20-25% буурсан нь манай эдийн засаг огцом суларсаныг харуулна. Хөл хорио цаашид үргэлжлэх төлөвтэй боловч Монголын бизнесүүд хэр удаан тогтож чадах вэ?

Хэдийгээр Монгол Улс дийлэнхи орлогоо уул уурхайгаас олж байгаа боловч, энэ салбарт ажилладаг хүмүүсийн тоо манай нийт ажиллах хүчний 5% тэнцэх юм. Харин ажилчдын дийлэнхи хэсэг буюу 55 орчим хувь үйлчилгээний салбарт ажилладаг бөгөөд, вирусын дэгдэлтийн шууд нөлөөнд байгаа хэсэг юм. Үүнээс 230 мянган ажилчдын орлого, амьжиргаа хамгийн эрсдэлтэй хэсэгт тооцогдохоор байгаа бөгөөд, эдгээр хүмүүсийн ажлын байрыг хамгаалах арга хэмжээ яаралтай авахгүй аваас манай ажилгүйдлийн түвшин 30% давах эрсдэлтэй нөхцөл үүсээд байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Банк болон Санхүүгийн Тогтвортой Байдлын зөвлөлийн хурлуудаас хоёр том шийдвэр гараад байгаа нь, 1) Хэрэглээний зээлийн төлбөрийн хугацааг сунгасан, 2) Бодлогын хүү бууруулж, банкуудад тавих шаардлагуудыг сулруулсанаар, зээл нэмж гарах боломж бүрдүүлсэн юм.

Дээрхи хоёр гол шийдлүүд огт байхгүй байснаас дээр боловч өнөөгийн нөхцөл байдалд хангалтгүй байгаа юм. 1) Иргэдийн зээлийн хэсэг бол банкуудын нийт зээлийн багцын 58%г эзэлдэг, хамгийн эрсдэл багатай (чанаргүй зээлийн хэмжээ 3.5% дээр) хэсэг бөгөөд банкуудын жилийн үйл ажиллагааны орлогын төсөөллийн дийлэнхи хувийг эзэлдэг юм. Иргэдийн зээлийн эргэн төлөлтийг царцааснаар иргэдийн халааснаас гарах тогтмол зардалд томоохон нэмэр болж байгаа боловч, нөгөө талд байгаа нийт салбарын 500 тэрбум орчим төгрөгийн орлого тасарч байгаад шийдэл одоо болтол байхгүй байна. Банкны салбар нь жилийн 1 их наяд төгрөгний үйл ажиллагааны зардалтайгаар 30 мянган хүн ажилуулж, Монголын хүчтэй дундаж ангийг бүрдүүлдэг хэсэг. Гэвч 10 орчим их наяд төгрөгийн иргэдийн зээлийн эргэн төлөлт зогсоосонтой холбоотой гарах зардлыг хувийн хэвшлийн нуруун дээр үүрүүлсэн хэвээр байна. 2) Монгол Банк арилжааны банкуудын зээл гарах нөхцөлийг хөнгөвчилж өгсөн хэдий ч, коронавирусын онцгой цаг үеийн гол зорилт нь бизнесүүдийг аль болох хохирол багатай гаргах тал рүү чиглүүлэх ёстой. Юу гэсэн үг вэ гэвэл, онцгой үед бизнесүүдэд ажилчиддаа цалинг нь үргэлжлүүлэн тавих нийгмийн шинж чанартай санхүүгийн дэмжлэг илүү хэрэгтэй болохоос биш, бизнес зогссон үед арилжааны зориулалттай зээлээр цалингаа үргэлжлүүлж тавих сонирхол хэнд ч байхгүй болов уу.

Дэлхийн улс орнууд энэхүү онцгой үе ойрын 3-5 сарын турш үргэлжлэнэ гэсэн таамагтайгаар эдийн засгийн багц арга хэмжээнүүдийг аваад эхэлжээ. Багцуудын гол зорилтуудыг тоймлох аваас, 1) санхүүгийн зах зээлийн чөлөөт хөрвөх чанарыг хадгалах мөнгөний бодлогууд, 2) ажилчид болон ажлын байрыг хамгаалах төсвийн бодлого дээр үндэслэж байна.

Монгол улсын хувьд өөрийн онцлог сул болон давуу талуудтай. Манай 1.1 сая ажиллах хүчний 400 орчим мянган хүмүүс төсвийн байгууллага болон орлого нь 2.5 тэрбумаас дээш орлоготой том байгууллагад ажиллаж байна. Нөхцөл байдал доройтлоо гэхэд эдгээр хүмүүсийг ямар нэгэн байдлаар том компаниуд аргалаад гарах санхүүгийн чадамжтай гэж найдна. 300 орчим мянган хүн мал аж ахуй эрхэлж байгаа бөгөөд энэ долоо хоногт яригдсан ноос ноолуурын онцгой үеийн бодлогоор эдгээр хүмүүсийн орлогыг таслахгүй цагаа олсон алхам гэж үзэж байна. Эрсдэлтэй хэсэг бол худалдаа, үйлчилгээний салбарын 75 мянга орчим аж ахуйн нэгжид ажилладаг 230 гаруй мянган иргэд байгаа юм. Үүнээс, 150 мянган хүн нь жилдээ 50 сая төг хүртэл борлуулалтын орлого хийж, 10 хүртэл хүн ажилуулдаг худалдаа, үйлчилгээний салбарын жинхэнэ жижиг дунд бизнесийнхэн бөгөөд вирусын тархалттай холбоотой хамгийн эмзэг бөгөөд эрсдэлтэй бүлэг мөн юм.

Дээрхи нөхцөл байдлыг тооцож, УИХ болон Засгийн Газар яаралтайгаар дараах чиглэлээр шийдэл гаргах хэрэгтэй байгаа юм:

1. 2020 оны төсвийг тодотгож, учирч болох алдагдалууд дээр ойлголттой болох;

2. Банк, санхүүгийн салбарт зээл төлөлт зогсоож, зээлийн ангилал бууруулах хугацааг 180 хоног хүртэл сунгаж байгаагаас үүдэн гарах алдагдлыг нөхөх;
3. Худалдаа, үйлчилгээний салбарын тогтмол зардлууд болох түрээс, тог цахилгааныг царцаах;
4. Худалдаа, үйлчилгээний түрээсийн орлого тасарсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн алдагдлыг нөхөх;
5. Жижиг дунд бизнесүүдийн орлого тасарсан аж ахуйн нэгжүүдийн ажилчдын цалинг үргэлжлүүлэн өгөх, өгөхтэй холбоотой зардлыг даах;
6. Томоохон компаниуд бага хүүтэй өрийн бичиг гаргаж, Төв Банк худалдан авах ажиллагаа хийх (Европын төв банк, Английн Банк хийж байгаа)
7. Нийгмийн даатгал, болон бусад төрийн татвар шимтгэлийг онцгой үед зогсоох

Вирусын тархалтыг зогсоохоор авсан арга хэмжээнүүд одоо амжилттай ажиллаж байгаа хэдий ч, манай бизнесүүд үргэлжилсэн хөл хориог тэсэж гарах нөхцөл улам цөөрсөөр байна. Аливаа Засгийн газрын үндсэн үүрэг иргэдээ эрүүл орчинд хөдөлмөрлөх орчиноор хангахад оршидогийн адил, манай Засаг ч хамгийн мууд бэлдэж, төсвийн алдагдал болон дээрхи хөтөлбөрүүдийн өртөг, санхүүжүүлэх эх үүсвэрээ тодорхойлоод, зохицуулах ажилдаа нэн яаралтай орох хэрэгтэй юм. Мянга мянган хүмүүсийн ажлын байр эрсдэлд орсон байна.

М. Сугар

2020 оны 03 Сарын 20 өдөр